

**МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ
ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛСЭЭР ТАЙЛБАРЛАХ
НЬ**

Оюутан: Б.Нарангэрэл

Удирдагч багш: Б.Бат-Эрдэнэ /магистр/

ШУТИС-Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн сургууль, Санхүү Менежмент, 3-р курс

Э-уудан: *nangii.bataa@gmail.com*

Утас: 98844114, 99714083

Хураангуй

Энэхүү судалгаагаар Монгол улсын иргэдийн санхүүгийн боловсролыг санхүүгийн мэдлэг, хандлага, зан төлөвт задлан хүн ам зүй, нийгэм эдийн засгийн хүчин зүйлсээр тайлбарлав. Ердийн хамгийн бага квадратын аргаар идэвхгүй хувьсагчтай регрессийн тэгшитгэл байгуулан харахад санхүүгийн боловсрол нь хүйс, орлого, ажлын туршилагаас хамаарахгүй байгаа бол өндөр боловсролтой, санхүүгийн хөрөнгөтэй, банк санхүүгийн салбарт ажилладаг санхүүгийн мэдээлэлд ойр байдаг, нийслэл хотод амьдардаг, өмнө нь ямар нэг санхүүгийн залиланд өртөж байгаагүй, 35 нас хүртэлх залуу иргэдийн санхүүгийн боловсрол илүү өндөр байна. Мөн санхүүгийн боловсролын 3 бүрэлдэхүүн хэсгийн хувьд авч үзвэл хүн ам зүй, нийгэм-эдийн засгийн хувьсагчдаас хамааран иргэдийн санхүүгийн мэдлэгийн ялгаа их, харин санхүүгийн зан төлөв ба хандлагын ялгаа бага байна. Өөрөөр хэлбэл иргэдийн санхүүгийн мэдлэг ялгаатай байгаа боловч, мэдлэгээ ашиглах чадвар, төлөвшил нь ялгаагүй байгааг харуулж байна.

Түлхүүр үгс: санхүүгийн боловсрол, санхүүгийн мэдлэг, санхүүгийн зан төлөв, санхүүгийн хандлага, хүн ам зүй болон нийгэм эдийн засгийн шинж чанарууд

Удиртгал

Монгол улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжээд 30 жил өнгөрчээ. Энэ хугацаанд банк, санхүүгийн салбарын хувьд эхний 10 жилд хэд хэдэн банкууд дампуурсан тогтворгүй үе, дараагийн 10 жилд шинээр олон банк болон банк бус санхүүгийн байгууллагууд нээгдэж олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн бий болсон бойжилтын үе байсан бол сүүлийн 10 жилийн хугацаанд мэдээлэл, технологийн салбарын хурдацтай өсөлтийн үр дүн санхүүгийн салбарт нэвтэрснээр хурдацтай өсөлтийн үе тохиож байна. Иймд санхүүгийн зах зээл ба санхүүгийн шийдвэр гаргах нарийн төвөгтэй байдал улам бүр нэмэгдэж буй өнөө үед иргэдийн санхүүгийн боловсрол нь судлаачид болон бодлого боловсруулагчдын сонирхлыг ихээр татах болов. Орчин үеийн нийгэмд хүмүүс санхүүгийн төрөл бүрийн асуудалтай тулгарах нь элбэг болов. Нээлттэй зах зээлийн эдийн засагтай улс орнуудын засгийн газар нь зохицуулалтын хүрээнд тодорхой хэмжээний хамгаалалтыг бий болгодог хэдий ч эдийн засаг, санхүүгийн ажил гүйлгээнд амжилтанд хүрч байсан түүх алга байна. Санхүүгийн боловсрол нь санхүү, эдийн засгийн асуудлын мөн чанар, зан төлөвийг ойлгох боломжийг хүмүүст олгодог.

Өмнөх судалгааны ажлуудаар тэтгэврийн хадгаламжийн төлөвлөгөө, даатгалын бодлого, баялгийн хуримтлал, хэрэглээний шийдвэр, хөрөнгийн зах зээлийн хөрөнгө оруулалт нь санхүүгийн боловсролоос хамааралтай байгаа эсэхийг судалсан байна (Секита, 2013).

Санхүүгийн боловсролын ач холбогдлыг харгалзан үзээд АНУ-ын засгийн газар 2003 онд Санхүүгийн боловсролын тухай хуулийг баталсны дараа Санхүүгийн Боловсролын Комиссыг байгуулсан. Гэсэн хэдий ч залуучуудын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор JumpStart нэртэй ашгийн бус байгууллага 1995 онд байгуулагдсан. Их 20-ийн удирдагчдын 2012 оны тунхаглалд санхүүгийн боловсролын үндэсний стратеги боловсруулахыг нэн тэргүүнд тавьсан байна.

Марколин ба Абрахам (2006) нар санхүүгийн мэдлэгийн стандарт хэмжигдэхүүнийг олох шаардлагатайг онцолжээ. Санхүүгийн боловсролын ач холбогдлын талаар санал нэг байгаа хэдий ч түүний тодорхойлолт, хэмжилт нь судалгааны ажлуудад ихээхэн ялгаатай байдаг. Шмейзер ба Селигман (2013) нар судалгаанд хамрагдсан хүмүүс санхүүгийн мэдлэгтэй холбоотой асуултанд тууштай хариулт өгдөггүй тул санхүүгийн

мэдлэгийг хэмжихэд бэрхшээлтэй тулгардаг гэжээ. Тиймээс судлаачдад үр дүнг нь ойлгохын тулд санхүүгийн боловсролын зохих тодорхойлолт ба хэмжилт хэрэгтэй. Хьюстон (2010) нь 70 судалгааны ажлыг хянаж үзээд санхүүгийн боловсролын талаарх одоо байгаа тодорхойлолт, хэмжилтийн арга техниктэй холбоотой хэд хэдэн чухал баримтуудыг олж харжээ. Нэгдүгээрт, ихэнх судалгаанд тодорхойлолтыг оруулаагүй бөгөөд санхүүгийн боловсрол болон санхүүгийн мэдлэгийг ижил утгатай ашиглаж байсан. Хоёрдугаарт, тодорхойлолт оруулсан ихэнх судалгаанууд чадвар, мэдлэг хоёр дээр тулгуурладаг байсан бол АНУ-ын Санхүүгийн боловсролын комисс, Jump\$тарт эвсэл нь тодорхойлолтондоо санхүүгийн мэдлэг, чадварыг хоёуланг нь ашигласан болно. Санхүүгийн боловсролын комисс (2007) нь санхүүгийн боловсрол гэдэг нь санхүүгийн аж байдлаа дээшлүүлэхийн тулд санхүүгийн нөөцийг удирдахад мэдлэг чадварыг ашиглах чадвар юм гэж тодорхойлсон бол Jump\$тарт (2007) нь энэ бол насан туршийн санхүүгийн аюулгүй байдлын үүднээс хэн нэгний санхүүгийн нөөцийг үр ашигтай удирдахад мэдлэгээ ашиглах чадвар юм гэж тодорхойлсон байна. Санхүүгийн боловсрол нь нас, гэр бүл, соёл, оршин суугаа газар гэх мэт хувьсагчдаас хамааран өөрчлөгдөж байдаг. Иймд санхүүгийн боловсрол гэдэг нь хувь хүн, эдийн засгийн байнгын өөрчлөгдөж буй нөхцөл байдалд хүн бүр үр дүнтэй хариу үйлдэл үзүүлэх боломжийг олгодог хөгжиж буй чадварын түвшинг хэлнэ.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) нь санхүүгийн боловсролыг санхүүгийн ойлголт, эрсдэлийн талаарх мэдлэг, ойлголт, энэхүү мэдлэг, ойлголтыг санхүүгийн янз бүрийн хүрээнд үр дүнтэй шийдвэр гаргахад ашиглах замаар хувь хүн, нийгмийн санхүүгийн сайн сайхан байдлыг сайжруулах, эдийн засгийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэх ур чадвар, урам зориг, итгэл үнэмшил юм гэж тодорхойлжээ (ЭЗХАХБ, 2017).

Дэлхий даяар хийгдсэн бусад судалгааны үр дүнгээс харвал санхүүгийн ойлголтуудын талаарх хүмүүсийн ойлголтыг хэмждэг санхүүгийн боловсролын ердийн тодорхойлолтыг ашиглан хүн ам зүй, нийгэм-эдийн засгийн тодорхойлогч хүчин зүйлсийг олсон байна. Эдгээр үр дүнгээс дурьдвал эрчүүдийн санхүүгийн боловсрол эмэгтэйчүүдийнхээс илүү байсан. Дунд насны хүмүүс залуу болон ахмад настнуудаас илүү санхүүгийн мэдлэгтэй байсан.

Агарвал ба бусад (2009) хүмүүс туршлагаар дамжуулан санхүүгийн мэдлэгээ дээшлүүлдэг боловч танин мэдэхүйн чадвар буурснаас болж өндөр наснаасаа санхүүгийн мэдлэгээ алдаж эхэлдэг гэж нотолж байна. Судлаачид боловсрол нь танин мэдэхүйн чадварыг нэмэгдүүлдэг тул санхүүгийн мэдлэгийг дээшлүүлдэг гэж нотолсон (Gill and Prowse, 2015). Лусарди ба Митчелл (2011) нар боловсрол, санхүүгийн мэдлэг хоёрын хооронд эерэг холбоо байгааг харуулсан эмпирик нотолгоог өгдөг. Лусарди ба Митчелл нар (2011) ажилтай хүмүүс ажилгүйчүүдээсээ илүү санхүүгийн мэдлэгтэй байх хандлагатай байдаг нь тэдний ажлын байран дээр цуглуулсан туршлагаас шалтгаалдаг болохыг тогтоожээ. Орлого олох чадвар ба хөрөнгийн хэмжээ нь санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг.

Аткинсон ба Месси (2012) нар өрхийн орлого ба хөрөнгө нь санхүүгийн боловсролд эерэг хамааралтай байгааг харуулсан.

Энэхүү судалгаа нь санхүүгийн боловсролыг санхүүгийн мэдлэг, хандлага, зан төлөвийн үүднээс хэмжиж, санхүүгийн боловсролын хүн ам зүй, нийгэм эдийн засгийн тодорхойлогчдыг судлав. Бидний санхүүгийн мэдлэгийн хэмжүүр нь ЭЗХАХБ (2017)-ын гаргасан санхүүгийн ойлголтуудыг ойлгох байдал ба санхүүгийн мэдлэгийг ашиглах байдалд чиглэсэн санхүүгийн боловсролын тодорхойлолтыг дагаж мөрдсөн болно.

Хувьсагчид ба хэмжилтийн асуудал

Бид насны 4 бүлгээр 395 хүнээс онлайнаар 2021 оны 5-р сарын 1-нээс 10 хоногийн хугацаанд санамсаргүй түүврийн аргаар судалгаа авсан болно.

Хамааран хувьсагчид

Бидний судалгааны хамааран хувьсагч нь санхүүгийн боловсрол юм. Бид санхүүгийн мэдлэг, санхүүгийн зан төлөв, санхүүгийн хандлагын оноог нэгтгэн санхүүгийн боловсролын оноог гарган авсан. Мөн санхүүгийн мэдлэг, санхүүгийн зан төлөв, санхүүгийн хандлагыг хамааран хувьсагч болгон хүн ам зүй, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлсээс хамааруулан хи-квадрат тестийн аргаар хамаарлыг тооцож хавсралт 1-д харуулсан. Санхүүгийн боловсролыг илүү нарийвчлалтай хэмжихийн тулд бид санхүүгийн боловсролыг эдгээр гурван бүрэлдэхүүнээр авч үзсэн ба санхүүгийн мэдлэг,

хандлага, зан төлөвийн оноо өндөр байх нь судалгаанд оролцогчид зөвхөн мэдлэгтэй төдийгүй энэхүү мэдлэгээ санхүүгийн шийдвэр гаргахдаа сайн ашигладаг болохыг харуулна. Эдгээр гурван бүрэлдэхүүн хэсгийг бүрдүүлж байгаа асуултуудад тус бүр ижил жин өгсөн тул эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр оноогоор санхүүгийн боловсролыг хэмжсэн. Санхүүгийн мэдлэг, санхүүгийн хандлага, санхүүгийн зан төлөвийг хэмжих зорилгоор бид судалгааны хэд хэдэн асуултыг ашигласан.

Санхүүгийн мэдлэг нь хүүний түвшин, инфляци, үнэт цаасны эрсдэл ба өгөөж зэрэг санхүүгийн ойлголтууд, тэдгээрийн тооцоог хийж чадаж байгаа эсэхийг хэмждэг. Санхүүгийн мэдлэг нь хүмүүсийн санхүүгийн зан төлөв, хандлагыг төлөвшүүлэхэд шаардлагатай санхүүгийн чадварыг хөгжүүлдэг. Санхүүгийн мэдлэгийг хэмжихийн тулд бид хавсралт 3-ын 7, 8, 9-р асуултуудыг ашигласан болно.

Санхүүгийн зан төлөв нь хүмүүс санхүүгийн ажил гүйлгээгээ хэрхэн хийж байгааг хэмждэг. Өөрөөр хэлбэл сайн санхүүгийн шийдвэр гаргахын тулд санхүүгийн мэдлэгээ чадварлагаар ашиглаж байгаа эсэхийг хэмждэг. Ерөнхийдөө санхүүгийн мэдлэг ба хандлага нь хүмүүсийн санхүүгийн зан төлөвийг төлөвшүүлдэг. Бид санхүүгийн зан төлөвийг хэмжихийн тулд хавсралт 3-ын 1, 2, 3, 6-р асуултуудыг ашигласан.

Санхүүгийн хандлага нь хүмүүсийн санхүүгийн асуудалд хандах хандлагыг хэмждэг. Санхүүгийн мэдлэгтэй, чадварлаг хүмүүс санхүүгийн ажил гүйлгээнд эерэг хандлагатай байх болно гэж бид үзэж байгаа ч энэ нь үргэлж баталгаатай байдаггүй. Заримдаа хүмүүс өөрсдийн мэдлэг, ур чадвараа хандлага болгон төлөвшүүлж чадахгүй байх тохиолдол бий. Бид үүнийг хэмжихдээ хавсралт 3-ын 4, 5-р асуултуудыг ашиглав.

Мөн хамааран хувьсагчдын дамми хувьсагчдыг байгуулахдаа санхүүгийн боловсрол, санхүүгийн мэдлэг, санхүүгийн зан төлөв зэрэг хувьсагчдын хувьд 60-аас дээш хувь, санхүүгийн хандлага хувьсагчийн хувьд 50-аас дээш хувийн оноо авсан иргэдийг сайн буюу 1, бусад нь 0 гэсэн утга оноосон болно.

Үл хамааран хувьсагчид

Монгол улсын иргэдийн санхүүгийн мэдлэгийг тайлбарлахын тулд судалгаанд оролцогчдын хүн ам зүй, нийгэм-эдийн засгийн шинж чанаруудтай холбоотой хэд хэдэн хувьсагчийг оруулсан болно.

Хүснэгт 1. Үл хамааран хувьсагчид ба судалгааны таамаглал

№	Хувьсагч	Таамаглал
1	Хүйс	Эрчүүд эмэгтэйчүүдээс илүү санхүүгийн боловсролтой байдаг
2	Нас	Дундаж насны иргэд залуу болон ахимаг насны иргэдээс илүү санхүүгийн боловсролтой байдаг
3	Боловсрол	Боловсрол нь танин мэдэхүйн чадварыг дээшлүүлдэг тул санхүүгийн боловсролтой эерэг хамааралтай
4	Ажил эрхлэлтийн байдал	Ажил эрхэлдэг хүмүүс нь ажлын байрнаасаа туршлагажих замаар санхүүгийн боловсрол нь дээшилдэг
5	Өрхийн орлого	Орлого өндөртэй иргэд санхүүгийн боловсрол илүү өндөртэй байдаг
6	Өрхийн санхүүгийн хөрөнгө	Санхүүгийн хөрөнгө ихтэй иргэд илүү санхүүгийн боловсролтой байдаг
7	Санхүүгийн мэдээлэл авах давтамж	Санхүүгийн мэдээлэлд илүү ойр байдаг, богино хугацаанд олон давтамжтайгаар социал медиагаас мэдээлэл авдаг хүмүүсийн санхүүгийн боловсрол илүү өндөр байдаг.
8	Санхүүгийн залилан	Өмнө нь ямар нэг байдлаар санхүүгийн залиланд өртөж байсан хүн санхүүгийн боловсрол нэмэгдсэн байх магадлалтай
9	Ажиллаж буй салбар	Банк, санхүүгийн салбарт ажилладаг хүмүүс бусад салбарт ажилладаг хүмүүсээс илүү санхүүгийн боловсролтой байдаг
10	Амьдардаг газар	Нийслэл, хотод амьдардаг иргэд хөдөө орон нутагт амьдардаг иргэдээс илүү санхүүгийн боловсролтой.

Хавсралт 1-д энэхүү судалгаанд ашигласан хувьсагчдын тойм статистик мэдээллийг оруулсан болно. Судалгаанд оролцогчдын санхүүгийн боловсролын дундаж оноо 0.58 (SD = 0.49) байгаа нь дунджаас арай дээгүүр байгааг харуулж байна.

Санхүүгийн мэдлэг (дундаж = 0.49 ба SD = 0.5), санхүүгийн зан төлөв (дундаж = 0.41 ба SD = 0.49), санхүүгийн хандлага (дундаж = 0.44 ба SD = 0.49) зэрэг үзүүлэлтийн хувьд судалгааны оролцогчдын дундаж оноо бага байгааг харуулж байна. Судалгаанд оролцогчдын хүн ам зүй, нийгэм эдийн засгийн байдлыг авч үзвэл 47.3% нь эрэгтэйчүүд, 67.8% нь 35 хүртэлх настай, 51.4% нь 1-2,5 сая төгрөгийн орлоготой 40.3% нь 10 сая төгрөг хүртэл санхүүгийн хөрөнгөтэй, 79.4% нь дээд боловсролтой, 53.3% нь ажил эрхэлдэг, 30.1% нь ямар нэг байдлаар өмнө нь санхүүгийн залиланд өртөж байсан, 73.4% нь нийслэл хотод амьдардаг 65.8% нь ядаж 7 хоногт 1 удаа санхүү, эдийн засгийн мэдээллийг олж авдаг хүмүүс байна.

Арга зүй

Ердийн хамгийн бага квадратын аргыг ашиглан санхүүгийн боловсрол нь хүн ам зүй, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлсээс хэрхэн хамаарч байгааг идэвхгүй хувьсагчтай шугаман регрессийн загвар байгуулах замаар үнэлсэн. Шугаман регрессийн загварын тавил нь:

$$\text{Санхүүгийн боловсрол} = \alpha + \beta_1 \text{ хүйс} + \beta_2 \text{ нас} + \beta_3 \text{ боловсрол} + \beta_4 \text{ орлого} + \beta_5 \text{ санхүүгийн хөрөнгө} + \beta_6 \text{ ажил эрхлэлтийн байдал} + \beta_7 \text{ санхүүгийн асуудал} + \beta_8 \text{ санхүүгийн мэдээлэл} + \beta_9 \text{ ажиллаж буй салбар} + \beta_{10} \text{ амьдардаг газар} + \hat{\epsilon}$$

Судалгааны асуулгын (хавсралт 3) дагуу судалгааг авч хувьсагчдын тархалтыг шинжлэн үзсэний үндсэн дээр зарим хувьсагчдыг засварлан өөрчлөх замаар шинээр дамми хувьсагчдыг байгуулсан. Нас хувьсагчийн 5 бүлэг байсныг 25 хүртэлх насны 2 бүлгийг нэгтгэж бенчмарк категори болгон авсан ба үлдсэн 3 насны бүлгийг төлөөлөх дамми хувьсагч оруулсан. Боловсрол хувьсагч нь мөн 5 бүлэгтэй байсныг дээд боловсролтой ба бусад гэсэн 2 бүлэгтэй болгон нэгтгэж дээд боловсролтой иргэдийг төлөөлөх 1 дамми хувьсагчийг авч үзсэн. Манай судалгаанд огт санхүүгийн хөрөнгөгүй иргэд олон хамрагдсан тул энэхүү хувьсагчийг бенчмарк категори болгон авч 10 сая төгрөг хүртэл, 10

сая төгрөгөөс дээш санхүүгийн хөрөнгөтэй өрхүүдийг төлөөлөх дамми хувьсагчдыг авсан. Энэ мэтчилэн хувьсагчдын категориудыг нэгтгэсэн бөгөөд бага орлоготой өрх, бүтэн цагийн ажилгүй, санхүүгийн бус салбарт ажилладаг иргэд, санхүүгийн залиланд өртөж байгаагүй, сард 1 удаа эсвэл түүнээс цөөн давтамжтайгаар санхүүгийн мэдээлэл авдаг, хөдөө орон нутагт амьдардаг иргэдийг бенчмарк категори болгон авлаа.

Эмпирик үр дүн

Хавсралт 1-д санхүүгийн боловсрол, санхүүгийн мэдлэг, санхүүгийн зан төлөв, санхүүгийн хандлага гэсэн чанарын хувьсагчдыг хүн ам зүй, нийгэм-эдийн засгийн чанарын хувьсагчдаас хамааруулан хи-квадрат тестээр “бүлэг хооронд ялгаагүй” гэсэн тэг таамаглалыг шалгаж үзсэн.

Судалгаанд оролцогчид санхүүгийн боловсрол, мэдлэг, зан төлөв, хандлагаас үл хамааран сарын орлогоо мэддэг ба харин сарын зарлагаа мэддэг хүмүүс нь санхүүгийн мэдлэг илүү сайн байгааг харуулж байна. Мөн сайн дурын даатгалд хамрагдсан оролцогчдын санхүүгийн мэдлэг, зан төлөв сайн байна. Иргэд санхүүгийн бүтээгдэхүүнийг сонгохдоо ихэвчлэн вэбсайт (57.7%), хэвлэл мэдээллийн хэрэгсэл (46.6%), санхүүгийн байгууллагуудын товхимол (42.5%), санхүүгийн байгууллага (37.6%) ба мэргэжилтнүүдээс (37.5%) мэдээлэл авдаг гэж хариулжээ. Санхүүгийн боловсрол, мэдлэг, зан төлөв, хандлага нь судалгаанд оролцогчдын эцэг эх, асран хамгаалагчдын санхүүгээ хэрхэн удирдахыг зааж өгсөн эсэхээс, мөн зээлтэй эсэхээс ямар нэг хамааралгүй байна. Бусад хувьсагчдын тайлбарыг регрессийн үр дүнтэй хамт харьцуулан тайлбарлая.

Регрессийн шинжилгээг хийхдээ санхүүгийн боловсрол тоон хувьсагчийг хамааран хувьсагчаар авсан ба үр дүнгээс харахад санхүүгийн боловсролын түвшин нь хүйс, орлого, ажлын туршлага зэрэг хувьсагчдаас хамааран ялгаа гарахгүй байгаа бол нас хувьсагчийн хувьд 5 хувийн ач холбогдлын түвшинд 25 хүртэлх насны иргэдтэй харьцуулахад 26-35 насны иргэдийн санхүүгийн боловсролын ялгаагүй байхад харин 36-аас дээш насны иргэдийн санхүүгийн боловсролын түвшин бага байна. Дээд боловсролтой, санхүүгийн хөрөнгөтэй, банк санхүүгийн салбарт ажилладаг, санхүүгийн мэдээлэлд илүү ойр байдаг, нийслэл хотод амьдардаг иргэдийн санхүүгийн боловсрол илүү өндөр байна. Харин өмнө нь санхүүгийн залиланд өртөж байсан иргэдийн санхүүгийн боловсролын түвшин бага

байна. Эдгээр ихэнх үр дүнгүүд нь хи-квадрат тестийн үр дүнтэй ижил гарч байгаа ба санхүүгийн боловсрол нь өрхийн сарын орлогын ялгаанаас хамаарч байгаа эсэхийг хи-квадрат тестийн үр дүнгээс харахад хүчтэй хамаарал ажиглагдаж байгаа боловч регрессийн шинжилгээний үр дүнгээс харахад ялгаа харагдахгүй байна.

Дүгнэлт

Санхүүгийн боловсролын эдгээр гурван бүрэлдэхүүн хэсгийг хүн амын санхүүгийн боловсролын түвшинг илүү нарийвчлан тайлбарлах боломжийг олгож байна. Бидний үр дүнгээс харахад санхүүгийн боловсрол нь хүйс, орлого, ажлын туршлагаас хамаарахгүй байгаа бол өндөр боловсролтой, санхүүгийн хөрөнгөтэй, банк санхүүгийн салбарт ажилладаг санхүүгийн мэдээлэлд ойр байдаг, нийслэл хотод амьдардаг, өмнө нь ямар нэг санхүүгийн залиланд өртөж байгаагүй, 35 нас хүртэлх залуу иргэдийн санхүүгийн боловсрол илүү өндөр байна. Мөн санхүүгийн боловсролын 3 бүрэлдэхүүн хэсгийн хувьд авч үзвэл хүн ам зүй, нийгэм-эдийн засгийн хувьсагчдаас хамааран иргэдийн санхүүгийн мэдлэгийн ялгаа их, харин санхүүгийн зан төлөв ба хандлагын ялгаа бага байна. Өөрөөр хэлбэл иргэдийн санхүүгийн мэдлэг ялгаатай байгаа боловч, мэдлэгээ ашиглах чадвар, төлөвшил нь ялгаагүй байгааг харуулж байна.

Ашигласан материалын жагсаалт

Agarwal, S. J. (2009) “The Age of Reason: Financial Decisions over the Lifecycle”, *Brookings Papers on Economic Activity, Vol. 2*, 51–117.

Atkinson, A. and F-A. Messy (2012) “Measuring Financial Literacy: Results of the OECD / International Network on Financial Education (INFE) Pilot Study”, *OECD Working Papers on Finance, Insurance and Private Pensions, 15*. OECD Publishing.

Coalition, J. (2007) National Standards in K-12 Personal Finance Education. <http://www.jumpstart.org/guide.html>.

- Commission, U. F. (2007) “Taking Ownership of the Future: The National Strategy for Financial Literacy”, Found at <https://www.treasury.gov/about/organizational-structure/offices/Domestic-Finance/Documents/Strategyeng.pdf>
- Gill, D. and V. L. Prowse (2015) “Cognitive Ability, Character Skills, and Learning to Play Equilibrium: A level-k Analysis”, *Journal of Political Economy*, Vol. 124, No. 6, 1619-1676
- Huston, S. J. (2010). “Measuring Financial Literacy”, *Journal of Consumer Affairs*, Vol. 44, No. 2, 296-316
- Lusardi, A. and O. S. Mitchell (2007) “Financial Literacy and retirement Preparedness: Evidence and Implications for Financial Education”, *Business Economics*, Vol. 42, No. 1, 35–44
- Marcolin, S. and A. Abraham (2006) “Financial Literacy Research: Current Literature and Future Opportunities”, <http://ro.uow.edu.au/commpapers/223/>
- OECD (2017) “PISA 2015 Results: Students’ Financial Literacy”, Vol. 4. <http://dx.doi.org/10.1787/9789264270282-en>.
- Schmeiser, M. D. (2013). “Using the Right Yardstick: Assessing Financial Literacy Measures by Way of Financial Well-Being”, *The Journal of Consumer Affairs*, Vol. 47, No. 2, 243-262.
- Sekita, S. (2013). “Financial Literacy and Retirement Planning in Japan”, *Journal of Pension Economics and Finance*, Vol. 10, No. 4, 637-656.

Хавсралт 1. Чанарын хувьсагчдын хоорондын хамаарлын хи-квадрат тест

№	Асуулт	Давтамж ба хувь	Боловсрол (P утга)	Мэдлэг (P утга)	Зан төлөв (P утга)	Хандлагыг (P утга)
1	Санхүүгийн:					

	Боловсрол сайн <i>Mean (SD)</i>	229 (58%) 0.58	-	0.000	0.000	0.000
	Мэдлэг сайн <i>Mean (SD)</i>	(0.49) 196	0.000	-	0.001	0.000
	Зан төлөв сайн <i>Mean (SD)</i>	(49.6%) 0.49 (0.5)	0.000	0.001	-	0.004
	Хандлага сайн <i>Mean (SD)</i>	164 (41.5%) 0.41 (0.49) 176 (44.6%) 0.44 (0.49)	0.000	0.000	0.004	-
2	Та сарын орлого, зарлагаа мэдэх үү? Орлогоо мэднэ Зарлагаа мэднэ	353 (89.4%) 258 (65.3%)	0.437 0.071	0.057 0.000	0.419 0.537	0.373 0.664
3	Та сайн дураар ямар нэг даатгалд хамрагдсан уу? Тийм	117 (29.6%)	0.109	0.004	0.020	0.280
4	Санхүүгийн бүтээгдэхүүнийг сонгохдоо та хаанаас голчлон мэдлэг, мэдээлэл олж авдаг вэ? Вэбсайтуудаас Хэвлэл мэдээллийн хэрэгслээр Санхүүгийн байгууллагуудын товхимол Санхүүгийн байгууллага ба мэргэжилтнүүдээс	240 (57.7%) 194 (46.6%) 177 (42.5%) 156 (37.5%)	-	-	-	-
5	Таны хүйс? Эрэгтэй	187	0.597	0.014	0.629	0.501

		(47.3%)				
6	Таны нас? 25 нас хүртэл 26-35 нас 36-45 нас 45-с дээш нас	164 (41.5%) 104 (26.3%) 74 (18.7%) 53 (13.4%)	0.000	0.000	0.116	0.162
7	Таны ажлын статус Компаний ажилтан Төрийн албан хаагч Хувиараа бизнес эрхлэгч Цагийн ажил Өдрийн бүх цагийг гэрийн ажилд зарцуулдаг Оюутан Ажилгүй Бусад	125 (31.6%) 44 (11.1%) 42 (10.6%) 6 (1.5%) 15 (3.8%) 106 (26.8%) 44 (11.1%) 13 (3.3%)	0.173	0.013	0.269	0.155
8	Та аль салбарт ажилладаг, суралцдаг вэ? Банк, санхүүгийн салбар	64 (16.2%)	0.000	0.000	0.220	0.000
9	Таны эцэг эх эсвэл асран хамгаалагчид санхүүгээ хэрхэн удирдахыг танд зааж өгсөн үү? Тийм	69 (17.5%)	0.622	0.737	0.169	0.243
10	Та одоогоор зээлтэй юу? Ипотекийн Хэрэглээний	78 (19.7%)	0.280 0.142	0.940 0.836	0.722 0.074	0.848 0.061

	Бусад	113 (28.6%) 105 (26.6%)	0.000	0.003	0.288	0.000
11	Таны боловсролын түвшин Дээд боловсрол	290 (73.4%)	0.000	0.000	0.079	0.074
12	Та ямар нэгэн байдлаар санхүүгийн залиланд өртөж байсан уу? Тийм	119 (30.1%)	0.076	0.375	0.021	0.027
13	Та социал медиагаас санхүүгийн мэдээллийг ямар давтамжтай авдаг вэ? Ядаж 7 хоногт 1 удаа	260 (65.8%)	0.000	0.000	0.004	0.024
14	Та хаана амьдардаг вэ? Нийслэл, хот	290 (73.4%)	0.000	0.000	0.196	0.523
15	Танай өрхийн сарын орлого хэд вэ? 1 сая төгрөг хүртэл 1-2,5 сая төгрөг 2,5 сая төгрөгөөс дээш	98 (24.8%) 203 (51.4%) 94 (23.8%)	0.045	0.004	0.022	0.008
16	Танай өрхийн санхүүгийн хөрөнгө хэд вэ? Ямар нэг санхүүгийн хөрөнгө байхгүй 10 сая төгрөг хүртэл 10 сая төгрөгөөс дээш	128 (32.4%) 159 (40.3%) 108 (27.3%)	0.003	0.000	0.002	0.069

Хавсралт 2. Регрессийн тэгшитгэл

Coefficients^a

Model		Unstandardized Coefficients		Standardized Coefficients	t	Sig.
		B	Std. Error	Beta		
1	(Constant)	42.833	3.062		13.989	.000
	Хүйс	2.603	1.888	.063	1.378	.169
	26-35 нас	-3.178	2.537	-.068	-1.253	.211
	36-45 нас	-7.570	2.868	-.144	-2.640	.009
	45-аас дээш нас	-7.401	3.097	-.123	-2.390	.017
	Боловсрол	6.547	2.346	.141	2.791	.006
	10 сая төгрөг хүртэл санхүүгийн хөрөнгөтэй өрх	5.739	2.231	.137	2.572	.010
	10 сая төгрөгөөс дээш санхүүгийн хөрөнгөтэй өрх	8.505	2.825	.184	3.011	.003
	Дундаж орлоготой өрх	3.787	2.400	.092	1.578	.115
	Өндөр орлоготой өрх	2.671	3.192	.055	.837	.403
	Ажлын статус	2.776	2.178	.067	1.275	.203
	Ажиллаж буй салбар	8.399	2.636	.150	3.187	.002
	Санхүүгийн залиланд өртөж байсан эсэх	-4.892	2.052	-.109	-2.383	.018
	Санхүүгийн мэдээллийг сошиал медиагаас авах давтамж	6.229	2.110	.144	2.952	.003
	Амьдардаг газар	6.684	2.244	.144	2.979	.003

a. Dependent Variable: Санхүүгийн боловсрол

САНХҮҮГИЙН МЭДЛЭГЭЭ ШАЛГАХ АСУУЛГА

Энэхүү асуулгыг бөглөөд санхүүгийн мэдлэгийн түвшингээ шалгаарай!

Энэхүү асуулгыг бөглөөд санхүүгийн мэдлэгийн түвшингээ шалгаарай!

1. Та сарын орлого, зарлагын хэмжээгээ мэддэг үү? Тус бүрд нь хариулна уу!
2. Хэрэв та ажилгүй болох, эдийн засгийн хямралд өртөх, хөдөлмөрийн чадвараа алдах болон бусад шалтгаануудын улмаас орлогогүй болох үед, хамгийн багадаа 3 сар ашиглах хуримтлалтай юү?
 - a. Тийм
 - b. Үгүй
 - c. Мэдэхгүй
3. Хулан, Нараа хоёр нас чацуу. Хулан 25 наснаасаа эхлэн жил бүр 1.0 сая төгрөг, Нараа 50 наснаасаа эхлэн жил бүр 2.0 сая төгрөг хадгалж, хуримтал үүсгэж эхэлсэн бол 75 насандаа тэдний хэн нь илүү хуримтлалтай байх вэ?
 - a. Хуримтлалын хэмжээ ижилхэн
 - b. Нараа. Жилд хадгалсан мөнгөний хэмжээ их.
 - c. Хулан. Урт хугацаанд мөнгө хадгалсан.
 - d. Хулан. Учир нь түүний мөнгө урт хугацаанд нийлмэл хүүгээр өссөн
 - e. Мэдэхгүй
4. Дараахаас аль нь буруу сонголт вэ? *Гэрээ байгуулах үед..... нь тохиромжгүй.
 - a. Гэрээ үнэхээр шаардлагатай эсэхийг дахин авч үзэх.
 - b. Гэрээг цуцлах боломжтой эсэх, үүнд торгууль ногдуулж байгаа эсэхийг шалгах.
 - c. Үйлчилгээ үзүүлэгчийн дэлгэрэнгүй тайлбарыг үндэслэн гэрээ байгуулж, дараа нь гэрээний баримт бичгийг анхааралтай унших.
 - d. Гэрээ байгуулахдаа шаардлагатай бол гуравдагч этгээдээс зөвлөгөө авах.
 - e. Мэдэхгүй.

5. Дараахаас аль нь буруу сонголт вэ? *Санхүүгийн асуудалд өртөхгүйн тулд..... нь тохиромжгүй.

- a. Хувийн мэдээллээ алдахгүй байх.
- b. Санхүү, эдийн засгийн мэдлэгтэй байх, суралцах.
- c. Шийдвэр гаргаж чадахгүй үед, бүх асуудлыг үйлчилгээ үзүүлэгч этгээдэд даатгаж үлдээх.
- d. Худалдан авахаар төлөвлөж буй бүтээгдэхүүнийхээ мэдээллийг, бусад хэрэглэгчийн сэтгэгдлээс шалгах
- e. Мэдэхгүй

6. Интернет гүйлгээтэй холбоотой тохиромжгүй үйлдлийг сонгоно уу?

- a. Аюулгүй байдлын програм хангамжаа хамгийн сүүлийн хувилбараар шинэчилэх
- b. Үл мэдэгдэх хаягаас илгээсэн имэйлийг нээхгүй байх.
- c. Интернет кафегийн компьютер ашиглан банкны шилжүүлэг хийх
- d. Гүйлгээ хийхээс өмнө оруулсан мэдээллүүдээ олон дахин нягтлах
- e. Мэдэхгүй

7. Санхүүгийн талаарх ерөнхий мэдлэгээ бусад хүмүүстэй харьцуулбал та хэрхэн үнэлэх вэ?

- a. Маш өндөр
- b. Өндөр
- c. Дундаж
- d. Бага
- e. Маш бага
- f. Мэдэхгүй

8. Та 1.0 сая төгрөгийг жилийн 8 хувийн хүүтэйгээр банкинд хадгалуулахад, 1 жилийн дараа таны хадгалуулсан мөнгө хэдэн төгрөг болох вэ? Татвар харгалзахгүй, нэмэлт орлого нэмэхгүй. Тоогоор хариулна уу. *

-

- Мэдэхгүй

9. Та 1.0 сая төгрөгийг жилийн 8 хувийн хүүтэйгээр банкинд хадгалуулахад, 1 жилийн дараа таны хадгалуулсан мөнгө хэдэн төгрөг болох вэ? Татвар харгалзахгүй, нэмэлт орлого нэмэхгүй. Тоогоор хариулна уу. *

- a. 1.4 сая төгрөгөөс дээш
- b. 1.4 сая төгрөг
- c. 1.4 сая төгрөгөөс бага
- d. Өгөгдсөн мэдээллээр хэлэх боломжгүй
- e. Мэдэхгүй

10. Та сайн дурын даатгалд хамрагдсан уу?

- a. Гийм
- b. Үгүй

11. Та дараах мэдэгдлүүдийг үнэн эсвэл худал болохыг тодорхойлно уу. Зүйл тус бүрт нэг хариултыг сонгоно уу.

	Үнэн	Худал	Мэдэхгүй
Өндөр инфляци нь амьжиргааны өртөг хурдацтай нэмэгдэж байгааг илэрхийлнэ			
Харьцуулж үзвэл 15 жилийн хугацаатай ипотекийн зээл нь 30 жилийн хугацаатай зээлээс сар бүр илүү өндөр төлбөр шаарддаг боловч зээлийн хугацаанд төлсөн нийт хүү бага байх болно.			
Өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт өндөр эрсдэлтэй байх магадлалтай			
Нэг компанийн хувьцааг худалдаж авах нь олон компанийн хувьцааг худалдан авахаас илүү найдвартай өгөөж өгдөг			

12. Санхүүгийн бүтээгдэхүүнийг сонгохдоо та хаанаас голчлон мэдлэг, мэдээлэл олж авдаг вэ? "Санхүүгийн бүтээгдэхүүн" гэдэгт санхүүгийн байгууллагууд дахь хадгаламж, үнэт цаас, даатгалын бүтээгдэхүүнүүдийг хамруулж болно. 3-аас дээш хариулт сонгоно уу?

- a. Санхүүгийн байгууллагуудаас зөвлөгөө авах (үйлчилгээний ажилтнуудаас нэмэлт тайлбар авах)
- b. Санхүүгийн байгууллагуудын гаргадаг товхимлуудаас.
- c. Лекц эсвэл семинар дээр.
- d. Санхүүгийн мэргэжилтнүүд / санхүүгийн мэргэжлийн зөвлөхүүдээс зөвлөгөө авах
- e. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж (телевиз, радио нэвтрүүлэг, сонин, сэтгүүл гэх мэт)
- f. Цахимаар/Веб, FB, Влог бусад/
- g. Гэр бүлийн гишүүд / найз нөхөдтэйгээ ярилцах
- h. Их сургуулийн лекц, сургалтанд хамрагдах(насанд хүрэгчдэд зориулсан)
- i. Бусад мэдээллийн эх сурвалж ()
- j. Би ямар эх сурвалжаас мэдлэг, мэдээлэл олж авах боломжтойг сайн мэдэхгүй байна
- k. Би санхүүгийн бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалт хийдэггүй

Дараах асуултууд нь танай болон танай гэр бүлийн тухай юм.

13. Таны хүйс:

- a. Эрэгтэй
- b. Эмэгтэй

14. Та хэдэн настай вэ?

15. Дараахаас аль нь таны одоогийн ажлын статусыг хамгийн сайн тодорхойлж байна вэ?

- a. Компанийн ажилтан
- b. Төрийн албан хаагч
- c. Хувиараа бизнес эрхлэгч

- d. Цагийн ажил
- e. Гэрийн эзэгтэй
- f. Оюутан
- g. Ажилгүй
- h. Бусад ()

16. Та ажил хийдэг бол ямар салбарт ажилладаг вэ?

- a. Санхүүгийн салбарт (банк, ббсб, даатгал, татвар зэрэг орно)
- b. Бусад салбарт

17. Та зээлд хамрагдаж байсан уу?

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
Ипотекийн зээл			
Хэрэглээний зээл			
Бусад зээл			

18. Таны боловсролын түвшин? (Хэрэв та оюутан бол хэд дүгээр курс гэдгээ бичнэ үү)

- a. Дунд сургууль
- b. МСҮТ, тусгай мэргэшил
- c. Бакалавр
- d. Магистр ба доктор
- e. Бусад ()

19. Таны эцэг эх эсвэл асран хамгаалагчид санхүүгээ хэрхэн удирдахыг зааж өгсөн үү?

- a. Тийм
- b. Үгүй

20. Та ямар нэг байдлаар санхүүгийн залиланд өртөж байсан уу?

- a. Тийм
- b. Үгүй

21. Та сонин, сэтгүүл, телевиз, интернет гэх мэт эх сурвалжаас санхүү, эдийн засгийн мэдээллийг хэр олон удаа авдаг вэ?

- a. Өдөр бүр
- b. Долоо хоногт нэг удаа
- c. Сард нэг удаа
- d. Дээрхээс цөөн удаа
- e. Хэзээ ч үгүй
- f. Бусад

22. Та хаана амьдардаг вэ?

- a. Нийслэл, хот
- b. Хөдөө, орон нутаг

23. Эдгээр ангиллын аль нь таны өрхийн сарын орлогыг харуулж байна вэ?

- a. Ямар ч орлого олоогүй
- b. 1 сая ₮ хүртэл
- c. 1-1,5 сая ₮ хүртэл
- d. 1,5-2,5 сая ₮ хүртэл
- e. 2,5-5 сая ₮ хүртэл
- f. 5-10 сая ₮ хүртэл
- g. 10 сая ₮-с дээш

24. Танай өрхийн санхүүгийн хөрөнгө (хадгаламж, хувьцаа г.м.) одоогоор эдгээр ангиллын алинд нь багтдаг вэ?

- a. Ямар нэг санхүүгийн хөрөнгө байхгүй
- b. 10 сая ₮ хүртэл
- c. 10-30 сая ₮ хүртэл
- d. 30 сая ₮-с дээш

Хавсралт 4

